

ТАНИЛЦУУЛГА

“Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төсөл

Төрийн албаны зөвлөлөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу Ажлын албанаас “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам-ын төслийг боловсрууллаа.

Нэг.Журмын төсөл боловсруулсан зорилго, ач холбогдол

“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төсөл боловсруулсан зорилго нь Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, төрийн албаны шинэтгэл, Төрийн албаны зөвлөлийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг төв, орон нутгийн төрийн бүх байгууллагад хангах шаардлагаар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаа болон холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төслийн ач холбогдол нь Салбар зөвлөл Төрийн албаны зөвлөлийн бүтцийн нэгж болохыг баталгаажуулах, Салбар зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагааг тодорхойлох, томилох эрх бүхий этгээд, аливаа нөлөөллөөс ангид байлгах, Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийг орон нутаг, төрийн байгууллагад хэрэгжүүлэх, салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн эрх, үүргийг заах, цалин урамшууллын баталгааг хангахад оршино.

Хоёр.Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Улсын Их Хурлаас 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хуулиар Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулж байсан бөгөөд уг хууль нь Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэнтэй холбогдуулсан хүчингүй болсон.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-аар салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулж байна.

Гурав.Журмын төсөл боловсруулахтай холбогдуулан төсөл санаачлагчаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 12 дугаар хуралдаанд “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төслийн үзэл баримтлалыг танилцуулж, үүрэг чиглэл авсан.

Төрийн албаны зөвлөл, Зөвлөлийн дарга, гишүүдийн өгсөн үүрэг чиглэл, саналын дагуу “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төслийг боловсруулсан болно.

Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төслийг дэмжсэн нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим хуудаст журмын төслийг байршуулж олон нийтээс санал авах, Салбар зөвлөлд хүргүүлж мөн санал авах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Дөрөв.Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төсөл нь 8 зүйл /бүлэг/, 42 хэсэг, 33 заалт, 31 дэд заалттай болно.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны журмын төслийн зорилго нь салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтоох, салбар зөвлөл байгуулах, салбар зөвлөлийн чиг үүргийг тодорхойлох, үйл ажиллагааны зохион байгуулалт, тайлагнах болон бусад харилцааг зохицуулахад оршино.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны журмын төсөл нь нэгдүгээр бүлэг нийтлэг үндэслэл, хоёрдугаар бүлэг салбар зөвлөл байгуулах, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, гуравдугаар бүлэг салбар зөвлөлийн чиг үүрэг, дөрөвдүгээр бүлэг салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүний эрх, үүрэг, тавдугаар бүлэг салбар зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт, зургадугаар бүлэг салбар зөвлөлийн үйл ажиллагааны мэдээ, тайлан, үр дүнг үнэлэх, долоодугаар бүлэг салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал, наймдугаар бүлэг бусад гэсэн ерөнхий бүтэцтэй байна.

Нийтлэг үндэслэл гэсэн нэгдүгээр бүлэгт салбар зөвлөл нь Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхийг орон нутаг, төрийн байгууллагад хэрэгжүүлэх нэгж, хамтын удирдлага бүхий хараат бус байгууллага болох талаар тусгасан. Мөн энэ бүлэгт Төрийн албаны зөвлөл салбар зөвлөлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, салбар зөвлөл Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон салбар зөвлөл нь тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх талаар оруулсан.

Салбар зөвлөл байгуулах, салбар зөвлөлийн бүрэлдэхүүн гэсэн хоёрдугаар бүлэгт аймаг, нийслэлд салбар зөвлөл байгуулах, яам, агентлаг, Төрийн албаны тухай хуулийн 18.7-д заасан байгууллага, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай байгууллагын асуудал хариуцсан Салбар зөвлөлийг Төрийн албаны зөвлөлийн дэргэд ажиллуулах талаар тусгасан.

Салбар зөвлөлийн дарга орон тооны байх бөгөөд дарга нь төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн ангиллын албан тушаал байх, салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг Төрийн албаны зөвлөл томилж, чөлөөлдөг байх, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албаны төлөөллийг оролцуулах талаар тусгасан. Аймаг дахь Салбар зөвлөл нь 9-11 хүртэл, нийслэл дэх Салбар зөвлөл нь 11-13 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнд томилох эрх бүхий этгээдийг оруулахгүй болно.

Салбар зөвлөлийн чиг үүрэг гэсэн гуравдугаар бүлэгт Салбар зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийг зохион байгуулалтын /нийтлэг/, төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, төрийн албаны нөөц бүрдүүлэх, маргаан хянан шалгах, төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах, хяналт тавих, аудит хийх, сургалт сурталчилгаа, судалгаа хийх, хүний нөөцийн бодлогын гэсэн 8 хүрээнд багцлан тусгасан. Улсын Их Хурал, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс батлан гаргасан журамд заасан салбар зөвлөлийн бүрэн эрхийг нэгтгэн тусгах, Төрийн албаны тухай хуульд заасан Төрийн албаны зөвлөлийн бүрэн эрхээс орон нутагт хэрэгжүүлэх бүрэн эрхийг нэмж тусгах, бусад шаардлагатай чиг үүргийг тодорхойлох арга замаар Салбар зөвлөлийн чиг үүргийг боловсруулсан.

Салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүний эрх, үүрэг гэсэн дөрөвдүгээр бүлэгт дарга, нарийн бичгийн дарга, гишүүний хэрэгжүүлэх эрх, үүргийг тус тусад нь одоо мөрдөж байгаа Салбар зөвлөлийн журамд тулгуурлан тусгасан.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт гэсэн тавдугаар бүлэгт үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан болох, хуралдааны болон шийдвэр гаргах ирцийн талаар зааж, хуралдааныг дэгийг Салбар зөвлөл журамд нийцүүлэн өөрөө тогтоохоор заасан.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны мэдээ, тайлан, үр дүнг үнэлэх гэсэн зургадугаар бүлэгт салбар зөвлөл үйл ажиллагааны гүйцэтгэлийн мэдээг хагас жилээр, үйл ажиллагааны тайланг бүтэн жилээр гаргаж Төрийн албаны зөвлөлд ирүүлэх болон үйл ажиллагааны тайланг үнэлэх журам баталж мөрдүүлэх талаар тусгасан.

Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардал гэсэн долоодугаар бүлэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөл нь Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг төсөвтөө тусгаж санхүүжүүлэх талаар заасан.

Бусад гэсэн наймдугаар бүлэгт холбогдох хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгасан.

Тав.Журмын төсөлд тусгасан зарчмын шинэлэг зохицуулалт

“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын төсөлд дараах зарчмын шинэлэг зохицуулалт тусгасан болно.

-Төрийн албаны зөвлөл дэргэдээ яам, агентлаг, Төрийн албаны тухай хуулийн 18.7-д заасан байгууллага, хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай байгууллагын асуудлыг хариуцсан Салбар зөвлөл /3/-тэй байхаар тусгасан. Ингэснээр, Салбар зөвлөл үйл ажиллагаагаа Төрийн албаны тухай хуулийн хүрээнд хараат бусаар явуулах боломж бүрдэнэ гэж үзэж байна;

-Салбар зөвлөлийн дарга нь орон тооны байх бөгөөд төрийн захиргааны эрхэлсэн түшмэлийн ангиллын албан тушаалтан байна гэж заасан;

-Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн захиргаа, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан хаагчдын төлөөлөл орох, томилох эрх бүхий этгээдийг оролцуулахгүй гэдэг зарчмыг тусгасан бөгөөд бүрэлдэхүүнд орох албан тушаалтныг нэрлэн заасан;

-Салбар зөвлөлийн хэрэгжүүлэх чиг үүргийг багцлан тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА